



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/04

Өмнөдэлгэр сум

Сургуулийн дүрэм батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 5, 10, 13 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.1, 33.3, 34 дүгээр зүйлийн 34.2, 40 дүгээр зүйлийн 40.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 12, 13, 15, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.1, 17.6, 18 дугаар зүйлийн 18.8, 23 дугаар зүйлийн 23.2, 25 дугаар зүйлийн 25.2, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 6, 7 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн дүрмийг шинэчлэн хавсралтаар баталж, 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

2. “Сургуулийн дүрэм”-ийг нийт багш, ажилтанд танилцуулахыг сургалтын менежер (Ж.Наранцацрал, Ч.Хишигтогтох) нарт даалгасугай.

3. “Сургуулийн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, хэрэгжүүлэхийг нийт багш, ажилтанд үүрэг болгосугай.

4. Сургуулийн дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт шалгалтын багийн ахлагч (Э.Хэрлэн)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.СУГАРРАГЧАА

